

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2014 ОНЫ ТАЙЛАН

7.1. Хуулиар хүлээсэн үүргийн биелэлт

7.1.1 Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаархи мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах талаар

Холбогдох хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр ХЭҮК-ын цахим хуудас (www.mn-nhrc.org)-ны “Мэдээллийн ил тод байдал” хэсэгт үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү зэрэг ил байлгах шаардлагатай мэдээлэл, Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, холбогдох хууль тогтоомжийг бүрэн эхээр нь байршуулж олон нийт танилцах нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллалаа. 2014 оны 11 сарын байдлаар 180 хүн хандсан байна.

Мөн “Авлига ба түүний эсрэг олон улсын гэрээний зохицуулалт” сэдвээр нийтлэл бичиж өдөр тутмын 4 сонинд 2014.01.03-ны өдрийн дугаарт нийтлүүлсэн.

ХЭҮК-оос зохион байгуулсан дор дурдсан сургалтын хүрээнд “Авлига ба хүний эрх” Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрх” сэдвээр мэдээлэл хүргэж ажиллалаа.

Комисст шинээр томилогдсон 21 аймгийн ахлах мэргэжилтнүүдийг 2014 оны 01 дүгээр сарын 06-наас 10-нд, 08 дугаар сарын 20-ноос 25-ны өдрүүдэд тус тус 2 удаа дотоодын сургалтад хамруулах хүрээнд Авлигын эсрэг хууль, тогтоомж, хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах аргачлал сэдвээр хичээл зааж, байгууллагын дотоод дүрэм, журам, шаардлагатай ном, гарын авлагаар хангаж ажиллав.

2014 оны 04 дүгээр сараас 10 дугаар сар хүртэлх хугацаанд зохион байгуулсан “Хүний эрхийн нээлттэй өдөр” арга хэмжээний хүрээнд Ховд, Баян-Өлгий, Увс, Завхан, Өмнөговь, Дундговь, Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгуудын Татварын газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн ажилтнууд, ИТХ, ЗДТГ-ын ажилтнууд, ЕБС, цэцэрлэгийн эрхлэгч, менежер, нэгдсэн эмнэлгийн ажилтнууд нийт 1100 гаруй албан хаагчдад 27 удаагийн сургалтаар хүний эрхийн үндсэн ойлголт, хүний эрхэд суурилсан хандлага, хүний эрхийн олон улсын гэрээг хэрэглэх нь, мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрх, жендэрийн тэгш байдал, төрийн үйлчилгээ ба хүний эрх сэдвээр сургалт зохион байгуулсан. “Төрийн үйлчилгээ ба хүний эрх” сэдвийн хүрээнд иргэн төвтэй төрийн үйлчилгээ, иргэдийн хэрэгцээнд суурилсан үйлчилгээ, төрийн үйлчилгээний стандарт, ил тод байдал иргэний оролцоо, нууц хуйвалдаан, авлига, оновчтой чиг үүрэг, үр дүнд суурилсан удирдлага зэрэг агуулгаар мэдээллийг хүргэсэн болно.

“Хүний эрхийн төлөө сэтгүүлчид” клубын уулзалтыг 2014 оны 5 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулж сэтгүүлчдэд “Мэдээллийн ил тод байдал ба мэдэх эрх” сэдвээр мэдээлэл хийлээ.

2014 оны 6 дугаар сарын 18-ны өдөр Зоонозын хавдар судлалын үндэсний төвийн 40 ажилтанд Хүний эрхийн үндсэн ойлголт, эмнэлэгийн мэргэжилтнүүдийн ёс зүйн хэм хэмжээ сэдвийн хүрээнд авлига ба хүний эрхийн талаар хичээл заасан.

2014 оны 10 дугаар сарын 08-ны өдөр Галт тэрэгний хөдөлгөөн зохиуцуулалтын нэгдсэн төвийн 15 ажилтанд “Төрийн албан хаагчийн ёс зүй ба хүний эрхийг хүндэтгэх нь” сэдвийн хүрээнд төрийн албанд баримтлах зарчим, төрийн албаны нийгмийн хариуцлага, төрийн албан хаагчийн ёс зүй, төрийн албаны ёс зүй, төрийн албан тушаалтны Олон улсын ёс зүйн дүрэмд заасан Ерөнхий зарчмууд, “Сонирхлын зөрчил

болон эрхийг хасах”, “Хөрөнгийн мэдүүлэг”, “Бэлэг болон бусад шан харамж”, “Мэдээллийн нууцлал”, “Улс төрийн үйл ажиллагаа” зэрэг сэдвээр мэдээлэл бэлтгэн хүргэсэн болно.

Авлигатай тэмцэх газраас 2014 онд манай байгууллагад ирүүлсэн “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргагч нарт зориулсан гарын авлага” номыг ХЭҮК-ын нийт 40 ажилтанд тус бүр 1, Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах нь сургагч багшийн гарын авлага 2 ширхэгийг ХЭҮК-ын Бодлого, дүн шинжилгээ, хүний эрхийн боловсролын хэлтэст 2 ширхэгийг хүлээлгэн өгч холбогдох сургалтандаа ашиглаж байна.

7.1.2 Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох

Комисс Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх ээлжит 13 дахь илтгэлээ боловсруулан 2014 оны гуравдугаар сарын 27-ны өдөр Комиссын хурлаар хэлэлцүүлж гуравдугаар сарын 31-нд УИХ-д өргөн барьлаа. Илтгэлийг “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн 2014 оны 4 дүгээр сарын 25-ны №16 /829/-д нийтэлсэн. Мөн байгууллагын цахим хуудас www.mn-nhrc.org –ийн “Эх сурвалж” цонхны “Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл” хэсэгт ХЭҮК-ын жил бүрийн илтгэлийг байршуулж, иргэд олон нийтэд танилцах боломжийг бүрдүүлсэн. 2014 оны илтгэл-13-ийг нийт 2500 хувь монгол хэл дээр, 300 хувь англи хэл дээр ном болгон хэвлүүлж тараагаад байна.

ХЭҮК-ын Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэлийг Иргэний нийгмийн байгууллагуудаар хэлэлцүүлэх ажлыг 2014 оны тавдугаар сарын 21-ний өдөр Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэргэдэх Иргэний танхимд зохион байгуулж, нийт 67 хүн оролцож санал бодлоо солилцлоо. Илтгэлийг УИХ-д өргөн барьсан тухай мэдээллийг 17 хэвлэл мэдээллийн хэрэгсэл шууд сурвалжилж, илтгэлд тусгагдсан асуудал, ХЭҮК-оос өгсөн санал зөвлөмж, иргэний нийгмийн байгууллагуудын уулзалт хэлэлцүүлгийн талаарх мэдээллийг 20 орчим хэвлэл мэдээллийн хэрэгслээр 40 гаруй удаа нийтэлж, нэвтрүүлэн сурталчлаад байна.

Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулахдаа Ерөнхийлөгчийн Тамгын газартай хамтран Иргэний танхимд 2014 оны 4 дүгээр сарын 9-нд хэлэлцүүлэг зохион байгуулж иргэний нийгмийн байгууллага, сонирхогч талуудыг оролцуулав. Түүнчлэн Комиссын дэргэдэх Орон тооны бус зөвлөлийн гишүүдэд танилцуулж, саналыг нь тусган Ерөнхийлөгчийн тамгын газарт хуулийн төслийн үзэл баримтлал, шинэчилсэн найруулгын төслийг хүргүүлэв.

Манай улсын эдийн засгийн хөгжилд барилгын салбарын оруулж буй хувь нэмэр ихэсч байгаатай уялдуулан хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, ажлын байрны эрүүл ахуйн асуудлаарх үндэсний бодлого, эрх зүйн орчныг улам боловсронгуй болгох, урьдчилан сэргийлэх зорилгоор ОУХБ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг дэмжих суурь тогтолцооны тухай 2006 оны 187 дугаар конвенц болон Барилгын салбар дахь аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 1988 оны 167 дугаар конвенцийг тус тус соёрхон батлах, хууль тогтоомжид зохих нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг яаралтай судалж шийдвэрлэхийг санал болгож Монгол Улсын Ерөнхий сайд, Улсын Их Хурлын дарга, Гадаад харилцааны яам, Хууль зүйн яам, Хөдөлмөрийн яам, Барилга, хот байгуулалтын яаманд албан бичиг хүргүүлж, нөлөөллийн ажил зохион байгуулав. Уг саналын дагуу Гадаад харилцааны яам болон Хөдөлмөрийн яамнаас Комисст гэрээнд нэгдэн орохыг

дэмжиж байгаага илэрхийлсэн хариу ирүүлж, Хөдөлмөрийн яам дээр Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

Комисс хууль тогтоомж, бодлого шийдвэрийн төсөлд хүний эрхийн үүднээс дүн шинжилгээ тогтмол хийж 2014 онд нийт 11 хуулийн төсөлд санал хүргүүлсэн байна.

Үүнд:

1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (шинэчилсэн найруулга) 2014.01.29.
2. Гэмт хэргийн тухай хуулийн төсөл (ерөнхий анги) 2014.01.29.
3. Хөдөлмөрийн тухай хуулийн төсөл (шинэчилсэн найруулга) 2014.04.10.
4. “Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах, аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам”, “Нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах, хэрэглэх журам”, “Гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам”, “Гэрч, хохирогчид эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журам 2014.05.05.
5. Монгол Улс 2013 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протокол”-д нэгдэн орохоор гарын үсэг зурсны дагуу Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 2014.06.09.
6. Өршөөл үзүүлэх тухай хуулийн төсөл 2014.06.11.
7. Боловсролын тухай багц хууль (Боловсролын тухай, Дээд боловсролын тухай, Бага, дунд боловсролын тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай) (шинэчилсэн найруулга)2014.06.16.
8. Согтуурч, мансуурч донтох эмгэгтэй хүнийг албадан эмчлэх тухай хуулийн төсөл (шинэчилсэн найруулга) 2014.06.18.
9. Хотыг дахин хөгжүүлэх тухай хуулийн төсөл
10. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн төсөл ХАХНХЯ-ны дэргэдэх Ажлын хэсэгт орж ажиллаж байна.
11. НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн мэдээлэл хүргүүлэх журмын тухай нэмэлт протоколыг соёрхон батлах тухай хуулийн төсөл Хүүхдийн төлөө Үндэсний газрын хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэст e-майлаар хүргүүлсэн.

7.1.3 Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах

Хүний эрхийн Үндэсний Комиссын 2014 оны жилийн төлөвлөгөөнд нийт 7 хяналт шалгалтын ажил хийхээр төлөвлөсөн байна. Комиссын цахим хуудас www.mn-nhrc.org –ийн Мэдээллийн ил тод байдал цонхны Авлигын эсрэг үйл ажиллагаа хэсгийн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын авлигын эсрэг 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний зорилт 2-ын 7.1 заалтын хүрээнд Гомдол, хяналт, шалгалтын хэлтсээс хийж гүйцэтгэх хяналт, шалгалтын жагсаалтыг эндээс үзнэ үү. гэсэн хэсэгт, 2014 онд Комиссоос зохион байгуулсан хяналт шалгалт, шалгалтын мөрөөр авсан арга хэмжээний талаарх мэдээ, зөрчлийг арилгуулахаар арга хэмжээ авч шаардлага зөвлөмжийг хүргүүлсэн тухай мэдээллийг хагас жилийн байдлаар 2014.07.02-нд, 11 сарын байдлаар саяхан Комиссын цахим сайтын Мэдээллийн ил тод байдал цэст тус тус байршуулж олон нийт танилцах боломжийг бүрдүүлсэн.

7.1.4 Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх

Комиссын цахим хуудас www.mn-nhrc.org –ийн Мэдээллийн ил тод байдал цонхны Төсвийн ил тод байдал хэсэгт 2014 оны төсөв, 2013 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, тайлбар, 2015 оны төсвийн төсөл, 2014 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан, 2013 оны санхүүгийн тайлан, тайланд хийсэн аудитын дүгнэлт, 2014 оны төсвийн тодотгол (төсвийн тодотголыг 2014 оны төсөвд багана нэмж, тухай бүр шинэчлэн оруулсан) зэргийг Авлигын эсрэг хууль, мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу заасан хугацаанд нь тухай бүр байршуулж олон нийт танилцах боломжийг бүрдүүлсэн.

Комисс төсөвт ямар нэг орлого бүрдүүлдэггүй болно.

Хүний эрхийн Үндэсний Комисс 3 гишүүн, Ажлын Алба 46 ажилтантай. Комиссын гишүүдийг Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн дагуу Улсын их хурлаас 6 жилийн хугацаатай томилдог. Ажлын албаны ажилтнуудаас нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авсан болон эрх үүссэн ажилтан байхгүй, харин нийгмийн даатгалын сангаас тэтгэмж авсан ажилтнуудын жагсаалтыг цахим хуудасны Мэдээллийн ил тод байдал хэсэгт байршуулсан байгаа.

Хүний эрхийн Үндэсний Комисс нь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр “Монгол Улсад хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих үндэсний чадавхийг бэхжүүлэх нь” төслийг 2012-2014 онд хэрэгжүүлж байна. Энэ төсөл хөтөлбөрийн танилцуулга, зорилго, зорилт, гарах үр дүнгийн талаарх мэдээлэл болон төслийн 2012, 2013, 2014 оны 10 дугаар сарын байдлаарх дэлгэрэнгүй тайлан, мөн 2001-2013 онд тус Комисст хэрэгжсэн төслийн талаар мэдээллийг Комиссын цахим хуудас www.mn-nhrc.org-ны “Төсөл”-цонхонд мөн байгууллагын мэдээллийн самбарт байршуулж олон нийтэд нээлттэй мэдээлсэн

7.1.5 Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалтын хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих чиг үүрэгтэй байгууллага юм. Тус Комиссоос аливаа зөвшөөрөл, лиценз олгодоггүй болно.

7.1.6 Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах

Хүний эрхийн үндэсний Комисс үйл ажиллагаагаа орон нутагт хүргэж, үндэсний хэмжээнд ажиллах шаардлагын үүднээс Улсын их хурлаар шийдвэрлүүлж аймаг бүрд Комиссын ахлах мэргэжилтэн ажиллуулах болсон. 21 аймгийн сул орон тоог нөхөх захиалгыг Төрийн албаны зөвлөлд хандан нийтэд зарлаж, тухайн албан тушаалд тавьсан тусгай болон ерөнхий шаардлагыг хангасан иргэдээс сонгон шалгаруулж 2014 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс томилон ажиллуулсан. Мөн тус Комиссын Ажлын албаны Хэнтий аймгийн ахлах мэргэжилтэн ажлаас гарсан тул сул орон тоог нөхөх зарыг Төрийн албаны зөвлөл, ХЭҮК-ын цахим хуудас, байгууллагын мэдээллийн самбарт 2014 оны 4 дүгээр сарын 04-ний өдрөөс 2014 оны 5 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд Үндэсний шуудан 2014.04.18-ны дугаар 074 (2010), Зууны мэдээ 2014.04.18-

ны № 90 (4717), Монголын үнэн 2014.04.18-ны № 074 зэрэг өдөр тутмын 3 сонинд тус тус нийтлүүлж олон нийтэд нээлттэй мэдээлж, сонгон шалгаруулж томилсон.

Комисст 2013 оны 11 сарын 15-наас хойш нийт 23 сул орон гарсан бөгөөд нийтэд зарлаж 22 орон тоог нөхсөн 1 орон тоо одоо зарлагдсан байгаа.

7.1.7 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, 2014 оны төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авалтын гүйцэтгэлийг цахим хуудсандаа байршуулж олон нийт танилцах боломжийг бүрдүүлсэн.

Комиссын 2014 оны төсвийн хөрөнгө оруулалтын хуваарь өөрчлөх Сангийн сайдын тушаал 2 дугаар сард гарсан. Худалдан авалтын тендерийг Сангийн яамны Худалдан авах ажиллагааны удирдлага, хяналт мэдээллийн системээр буюу pmis.e-procurement.mn сайтаар дамжуулж олон нийтэд цахим хэлбэрээр зарлах ажлыг зохион байгууллаа. Мөн Оффисын тавилга худалдан авах тухай нээлттэй тендерийн урилгыг 2014.03.14-ний өдөр үндэсний хэмжээний өдөр тутмын Үндэсний шуудан №049 (1985), Зууны мэдээ (№062) 2 сонинд нийтэд зарласан.

Комиссын 2014 оны төсөвт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тоног төхөөрөмж, тавилга худалдан авах 105.0 сая төгрөг батлагдсан.

Худалдан авах ажиллагааны хууль, журмын дагуу 2014 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Комиссын орон нутгийн ажилтнуудад шаардлагатай тоног төхөөрөмж, тавилга худалдан авах нээлттэй тендер шалгаруулалтыг нийтэд зарлаж, ITZone, PC mall, BSB, Migma, Next computers зэрэг компаниудын үнийн санал ирсэнээс техникийн нөхцөлийг хангасан бөгөөд хамгийн хямд үнэ санал болгосон Саммит Компьютер Технологи ХХК (PC Mall дэлгүүр) шалгарч 43,540,000 төгрөгөөр тоног төхөөрөмж худалдан авахаар төлөвлөснөөс 43,538,700 төгрөгөөр худалдан авалт хийгдсэн. Мөн 61,460,000 төгрөгөөр албан тасалгааны тавилга худалдан авахаас нэг ч үнийн санал ирээгүй тул 3 дугаар сарын 14-ний өдрийн Үндэсний шуудан, Зууны мэдээ сониноор дахин нээлттэй тендер зарласан. БСБ трейдинг ХХК, Шинэ үе мэрси ХХК, Солонго тамир ХХК, Хашхан ХХК, Минторес ХХК гэсэн 5 компаний үнийн саналыг авсанаас бүгд төсөвт өртөгөөс давсан үнэтэй байсан тул хамгийн бага үнэ санал болгосон Минторес ХХК-тай дахин ярилцсаны үндсэн дээр тус компани анх санал болгосон үнээ буулгаж үнийн хөнгөлөлт үзүүлсэнээр гэрээ байгуулж 61,345,000 төгрөгөөр худалдан авалт хийсэн.

Худалдан авалтын үйл ажиллагааны үр дүн тайланг цахим хуудсандаа байршуулсан.

Тендер шалгаруулах явцад ямар нэгэн зөрчил, гомдол гараагүй.

2014 оны худалдан авах ажиллагаанд ирэх онд аудит хийгдэнэ.

Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд гаднаас хүн оролцуулаагүй бөгөөд тендерийн баримт бичиг дахь техникийн нөхцөл нь мэргэжлийн нарийн мэдлэг шаардагдахааргүй байсан тул өөрийн байгууллагын хүний нөөцийн боломж, чадавхи дээр тулгуурлан гүйцэтгэсэн болно.

7.1.8 Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох

Комиссын Ажлын албаны бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбоотойгоор 2014 онд нийт 17 албан тушаалын ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарийг шинэчлэн баталж мөрдүүлсэн.

Ажилтнуудын хариуцсан ажил үүргийн чиглэл, харилцах утас, и-мэйл хаягийг байгууллагын цахим хуудасны “Танилцуулга” цонхны “Ажлын алба” хэсэгт байршуулж олон нийт танилцах боломжийг бүрүүлсэн.

7.1.9 Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах

“Хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих үндэсний чадавхийг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэний нийгмийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх жижиг тэтгэлгийн хөтөлбөрийг хоёр дахь жилдээ зохион байгууллаа. Тэтгэлэгт хөтөлбөрийн зорилго нь хүний эрхийг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих чиглэлээр хөндлөнгийн хяналт үнэлгээ хийх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хүний эрхийн сургалт, мэдээлэл, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах талаар иргэний нийгмийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, тэдгээрийн үүсгэл санаачлага, үйл ажиллагааны тогтвортой байдлыг дэмжих, ХЭҮК болон иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оршино.

Төслийн нэр		Хэрэгжүүлэгч байгууллага	Мөнгөн дүн
1.	“Нэг цэгийн үйлчилгээ” төсөл	Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн Дархан-Уул аймаг дахь салбар ТББ	5,0 сая төгрөг
2.	“Монгол Улсад Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ боловсруулах нь” төсөл	Иргэний шийдэл ТББ	5,0 сая төгрөг
3.	“Хүний эрх-бүхний үндэс” төсөл	Гал голомт үндэсний хөдөлгөөний Орхон аймаг дахь салбар хүрээ ТББ	5,0 сая төгрөг
4.	“Бэлгийн дарамтгүй их сургууль” төсөл	“Өөрчлөлтийн төлөөх залуу эмэгтэйчүүд” ТББ	5,0 сая төгрөг
5.	“Удирдлагын дарангуйлал, ажлын байран дахь бэлгийн хүчирхийллийн талаарх мэдээллийн сан” төсөл	Хууль бидний амьдралд ТББ	5,0 сая төгрөг

Мөн Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоотой хамтран Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн саадгүй зорчих нөхцөлийг хангахад чиглэсэн “Авто замын байгууламж Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам Техникийн шаардлага MNS 5826-2006”, “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар MNS 6056-2009” зэрэг стандартуудын хэрэгжилтэд хяналт үнэлгээг хийж байна.

Энэ нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг хэрэгжүүлэх Засгийн газрын 2013-2016 оны Үйл ажиллагааны төлөвлөгөөний зорилт 4, зорилт 32 дахь заалт, мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг бодит болгоё” Инчеоны стратегийн зорилт 3-д тусгагдсан тул эдгээр заалтын хэрэгжилтийг үнэлэх, гарч буй ололт амжилт,

алдаа, дутагдлыг холбогдох мэргэжлийн байгууллагуудад хүргэн, хэрэгжилтийг хангуулах нөлөөллийн үйл ажиллагаа болно. Одоогоор 12 тэргэнцэртэй иргэд, сайн дурын ажилтнуудын хамт 2014 онд шинээр баригдсан явган хүний зам, гүүрэн байгууламжууд болон төрийн захиргааны төв болон үйлчилгээний байгууллагуудын хүртээмжтэй байдалд хяналт үнэлгээ хийсэн бөгөөд одоогоор тайлан боловсруулах ажиллагаа хийгдэж байна. Энэ үйл ажиллагаанд төслийн зүгээс нийт 1,368,000 төгрөгийг хяналт, үнэлгээний бодит зардалд үндэслэн зарцуулсан болно.

Хэрэгжүүлсэн ажил, хамтын ажиллагааны талаарх тайланг цахим хуудасны “Төсөл” цонхонд байршуулж олон нийтэд нээлттэй мэдээлсэн.

7.1.10 Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, үе асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтантай байх;

Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, Авлигатай тэмцэх газартай харилцан хамтран ажиллах эрх бүхий албан тушаалтныг тус Комиссын дотоод ажил хариуцсан референтэд 2007 оноос хойш хариуцуулан Комиссын даргын тушаалаар томилон ажиллуулж, эрх бүхий албан тушаалтан өөрчлөгдсөн тухай бүрд Авлигатай тэмцэх газарт албан бичгээр мэдэгдэж, тушаалын хуулбарыг хүргүүлэн, мэдүүлгийн цахим програмд шинэчлэн оруулж ажиллаж байна. “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын 3.1, 3.2-т заасны дагуу мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтны чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээнд тусган ажлын ачааллыг харгалзан 15 хувийн цалингийн нэмэгдлийг олгож байгаа.

Тайлангийн хугацаанд эрх бүхий албан тушаалтан дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

ХЭҮК-ын 2014 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны нэрийн жагсаалтыг гарган Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.

Тус Комиссын дарга, гишүүд нийт 46 албан хаагчдаас хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулан цаасан болон www.meduuleg.iaac.mn цахим хуудаст бүртгүүлэн, хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийн нэгдсэн тайланг хуулийн хугацаанд, Эрх бүхий албан тушалтны үйл ажиллагааны тайланг тус тус гаргаж Авлигатай тэмцэх газарт хүргүүлэв.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу тус байгууллагад томилогдохоор нэр дэвшсэн иргэдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг тухай бүр гаргуулан авч Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн, хариу дүгнэлтийг хүлээн авч ажиллаж байна.

2013 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс хойш нийт 31 иргэний хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн, хариуг авсан. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах, шалгаруулахад оролцох бүрд болон гэрээ байгуулах эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх оролцохын өмнө “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг маягтын дагуу гаргуулан авч, 2014.03.10-наас хойш нийт 8 мэдэгдэл хүлээн авч бүртгэсэн байна.

2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдрөөс хойш хугацаанд хөрөнгө орлогод нь их хэмжээний өөрчлөлт орсон 4 мэдүүлэг гаргагчийн мэдүүлгийг хуульд заасан хугацаанд нь шинэчлэн гаргуулж, цаасаар болон цахим програмд бүртгэж баталгаажуулсан байна.

Комиссын эрх бүхий албан тушаалтан Авлигатай тэмцэх газраас 2014.05.09-ний өдөр зохион байгуулсан “ЭБАТ-тай ярилцах цаг” сургалтад хамрагдаж, АТГ-аас тараасан гарын авлага материалаар сургалтын багц бэлтгэн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

7.1.11 Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1 дэх хэсэгт төрийн байгууллагын удирдлагад хүлээлгэсэн үүргийн дагуу Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Ажлын албаны ажилтны “Ёс зүйн дүрэм”-ийн төслийг боловсруулж, Авлигатай тэмцэх газраас санал авч, комиссын хурлаар хэлэлцүүлэн Комиссын даргын тушаалаар баталж, мөрдүүлээ.

Хүний эрхийн Үндэсний Комиссын Ажлын албаны ажилтны “Ёс зүйн дүрэм”-ийг бүрэн эхээр нь цахим оффисын программ www.able.mn–ийн Олон нийт цонхны Файлын сан хэсэгт Дүрэм журам дотор байрлуулж нийт ажилтнуудад мэдэгдэж, одоогоор 32 хэрэглэгч уншиж танилцсан байна. Мөн Комиссын www.mn-nhrc.org–ийн мэдээллийн ил тод байдал цонхны Хүний нөөцийн ил тод байдалд байршуулж олон нийт танилцах боломжийг бүрдүүлсэн болно.

Комиссын Ёс зүйн хороонд 2014 онд 1 гомдол ирснийг авч хэлэлцээд ёс зүйн зөрчил биш байсан тул арга хэмжээ аваагүй. Комисс нилээн судалсны үр дүнд Цахим оффисын программ www.able.mn–ийг 2014 оны 8 сараас ажиллуулснаар зөрчлийн талаарх мэдээллийг хэнээс ч хараат бусаар хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн. Одоогоор Ёс зүйн зөрчил илэрсэн тохиолдол гараагүй байна.

Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах, тайлан мэдээг цаг тухайд нь гаргаж танилцуулж байх үүргийг Комиссын даргын тушаалаар “Ёс зүйн хорооны дарга”-д хариуцуулсан билээ.

7.1.12 Давхар ажил эрхлэх боломж-той эсэхийг шийдвэрлэх

Хуулиар зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг цахим оффисын программ www.able.mn–ийн Олон нийт цонхны Зар мэдээ хэсэгт байрлуулж нийт ажилтнуудад мэдэгдэж, одоогоор 35 хэрэглэгч уншиж танилцсан байна. Мөн Комиссын www.mn-nhrc.org цахим хуудасны мэдээллийн ил тод байдал цонхны Хүний нөөцийн ил тод байдал хэсэгт байршуулж олон нийт танилцах боломжийг бүрдүүлсэн.

7.1.13 Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах

Байгууллагын нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтыг үндэслэн тус Комиссын албан хэрэг хөтлөлтийн шатанд байгаа болон архивт хадгалагдаж буй Комиссын дарга, Ажлын Албаны даргын тушаал, Комиссын даргын 2009 оны 13-р тушаалаар баталсан “Нууцын журам”-ын 2 дахь хэсэгт заасан нууцын зэрэглэлд хамаарах

баримт бичигтэй танилцах, судалгаа шинжилгээний зорилгоор ашиглах зөвшөөрлийг Ажлын албаны дарга олгохоор тогтоосон байдаг. Тиймээс цахим хуудсанд нээлттэй байрлуулдаггүй.

Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дотоод дүрэм журам байгууллагын цахим хуудасны “эх сурвалж”, дотоод сүлжээний SUN-AJLIIN Alba Folder-д нээлттэй баршуулснаас гадна “ХЭҮК-ын дотоод дүрэм журам, эрхзүйн баримт бичгийн эмхэтгэл” хавтасыг ажилтан бүрд, шинээр ажилд орсон ажилтанд 3 хоногийн дотор хүлээлгэн өгч танилцуулдаг журамтай.

Хүний эрхийн Комисс үйлчлүүлэгчээс аливаа нэг төлбөр хураамж авдаггүй болно

7.1.14 Иргэдийн өргөдөл (санал, мэдээгдэл) гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах

Хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчилах ажиллагааг тус Комисс өргөн хүрээнд явуулдаг.

Иргэдийн өргөдөл, гомдол хүлээн авах complaint@mn-nhrc.org цахим хаяг, хууль зүйн зөвлөгөө өгөх 70000222, 51-262971 дугаарын утсыг ажиллуулж байгаа талаарх мэдээллийг Комиссын цахимд, мөн сошиал медиа-Фейсбүүкт, ажлын байран дахь мэдээллийн самбарт, зурагт хуудаст, брошур, сэтгүүлд тус тус байршуулан олон нийтэд түгээж байна.

Гомдол хариуцсан референтүүдийн холбоо барих утас, и-мэйл хаягийг Комиссын цахим хаяг болон ажлын байран дахь мэдээллийн самбарт байршуулсан болно.

7.1.15 Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах

Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал үйлчилгээ тус Комисст байдаггүй тул ямар нэг жагсаалт гаргах шаардлаггүй гэж үзсэн.

7.1.16 Төрийн байгууллагын байранд түүний үйлчилгээг эрхэлдгээс бусад аж ахуйн нэгж, байгууллага байрлахыг хориглоно.

Хүний эрхийн Үндэсний Комисс нь Засгийн газрын 11 дүгээр байрны 5 давхарт 16 өрөө түрээслэн байрладаг.

7.1.17 Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх

Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн хуулийн хэрэгжилтийг хангах тухай 03/7007 дугаар зөвлөмжийн дагуу Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль мөрдөгдөж эхэлснээс буюу 2012 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс хойш ажил, албан тушаалд томилсон нийт 54 тушаалыг хянаж үзвэл тус Комисст төрийн захиргааны албан тушаалд шинээр томилогдсон нийт 31 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулсан байх бөгөөд, Комиссын дотоод бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлттэй холбоотой Комисст ажиллаж байгаа, мэдүүлэг гаргагч албан тушаалтанг хэлтэс дотроо ажил үүргийг нь өөрчлөн, сэлгэн ажиллуулсан, ангилал зэрэглэлийг ахиулсан, түр үүрэг гүйцэтгэгчээр томилоод чөлөөлсөн, жирэмсний амралттай байгаад эргүүлэн томилсон зэрэг 23 тохиолдолд хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянуулаагүй байна.

Эдгээрээс одоо тухайн албан тушаалд ажиллаж байгаа 5 мэдүүлэг гаргагчийг томилсон шийдвэр хүчингүй болохоор байгаа тул зөрчлийг арилгуулахаар Авлигатай тэмцэх газарт мэдүүлгийг хүргүүлж хянууллаа. Зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд хийсэн үйл ажиллагааны тайланг хугацаанд нь 4/643 дугаар албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлэв.

7.2. Авлигатай тэмцэх санал, санаачилга

7.2.1 Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх

Тус Комисс нь “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2014 оны төлөвлөгөө”-г 13 зорилтын хүрээнд 46 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөн Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллалаа. Төлөвлөгөөний биелэлт, тайланг төлөвлөгөөнд заасан үйл ажиллагааны зорилт бүрээр гаргаж тогтсон хугацаанд хүргүүллээ.

Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, ололт амжилт, хүрсэн үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын саналын тухайд ирсэн аргачлалын дагуу төлөвлөгөөг гаргаад хэрэгжүүлэхэд ололттой зүйл олон байгаа ч соён гэгээрүүлэх, сурталчлах асуудалд Комиссын төсөв хүрэлцэхгүй байна.

7.2.2 Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт

Хүний эрхийн Үндэсний Комиссын удирдлагууд Авлигатай тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөө, Ёс зүйн дүрэм батлан гаргаж, хэрэгжилтийн байдал тайланг цаг тухайд нь холбогдох байгууллагад хүргүүлж байна.

Байгууллагын удирдлагын санал, санаачлага

Комиссын авлигын эсрэг үйл ажиллагааны явц, Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн үнэлгээний учир шалтгааныг тодруулахаар Комиссын даргын үүрэг болгосноор дотоод хяналт шалгалтын ажлыг тус Комиссын Гомдол, хяналт шалгалтын хэлтсээс зохион байгуулж, дүнг 2014.03.04-ний өдрийн Комиссын хурлаар авч хэлэлцсэн болно.

Хурлаас холбогдох хүмүүст өгсөн заавар, чиглэл, хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг 2014.05.05-ны өдрийн Комиссын хурлаар авч хэлэлцлээ.

7.2.3 Албан хаагчдын шударга байдал ба түүнийг нэмэгдүүлэх

Албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх талаар тэдний саналыг үндэслэн дотоод сургалтын төлөвлөгөө гарган сар бүр сургалт зохион байгуулж ажиллалаа.

Комиссын орон нутгийн ажилтнуудад Авлигын эсрэг үйл ажиллагааны талаар сургалт зохион байгуулсан талаар уг тайланд дурдсан билээ.

Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үйл ажиллагааг ил тод үнэн зөв, шударга үнэлэх чиглэлээр Төрийн албаны зөвлөлтэй хамтран “Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам”-ын төсөл дээр ажиллаж байна.

Мөн Төрийн албаны зөвлөлтэй хамтран төрийн албан хаагчдад зориулсан хүний эрхийн цахим сургалт зохион байгуулах боломжийг судалж байна.

Комиссын дотоод хяналт шалгалтын хүрээнд авлигын зөрчил илрээгүй, бусад байгууллага, иргэдээс энэ талаар гомдол ирүүлээгүй болно.

.....o0o.....